



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 02 өдөр

Дугаар А/383

Ховд

Үндэсний бөхийн барилдаан
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.28 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 25 дугаар хуралдааны шийдвэр, аймгийн Онцгой комиссын 2021 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 53 дугаар тогтоол, аймгийн Үндэсний бөхийн холбооны хүсэлтийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үндэсний бөхийн барилдааныг 2021 оны 8 дугаар сарын 6-наас 9-ний өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд үзэгчгүйгээр зохион байгуулсугай.


2. Үндэсний бөхийн барилдааны зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Бөхийн барилдааныг тогтоосон хугацаанд “Үндэсний бөхийн барилдааны дүрэм”, холбогдох хууль, тогтоомж, журмын дагуу Улс, аймгийн Онцгой комиссын шийдвэр, чиглэл, коронавируст халдвар/Ковид-19/-аас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэмийн журам, зааврыг чанд мөрдөн үзэгчгүйгээр хариуцлагын гэрээний дагуу өндөр түвшинд зохион байгуулахыг Үндэсний бөхийн барилдааны зохион байгуулах комисс /Г.Цэдэнбалд/-т даалгасугай.

4. Бөхийн барилдаан зохион байгуулахад коронавируст халдварт /Ковид-19/ цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдвар хамгааллын дэглэм мөрдөх ерөнхий болон тусгай журам, зааврын хэрэгжилтэнд хяналт тавьж, оролцогч бөхчүүдээс коронавируст халдвар /Ковид-19/-ын хурдавчилсан тестээр шинжилгээ авч, бөхийн барилдаанд оролцогчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллахыг Эрүүл мэндийн газар /Ц.Мягмарсүрэн/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, Бүсийн оношилгоо эмчилгээний төв /П.Гэрэлсүрэн/ нарт үүрэг болгосугай.

5. Бөхийн барилдааны үед харуул хамгаалалтын болон нийтийн хэв журам сахиулах арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

A handwritten signature in black ink, appearing to read 'Б.Дүгэржав', is written over a red rectangular stamp. The stamp contains a central emblem and vertical text in Mongolian script on both sides.

Б.ДҮГЭРЖАВ

ҮНДЭСНИЙ БӨХИЙН БАРИЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Т.Дэлгэрсайхан - Аймгийн Засаг даргын орлогч
- Гишүүд: Г.Цэдэнбал - Аймгийн Үндэсний бөхийн холбооны тэргүүн
- С.Загдсүрэн - Одон орон, гео физикийн Ховд салбарын дарга
- Ч.Сүхбаатар - Биеийн тамир, спортын газрын албаны дарга
- Т.Баатарзориг - Бөхийн холбооны тэргүүлэгч
- Б.Даваасүрэн - Бөхийн холбооны тайлбарлагч
- Д.Уламбаяр - Ховд Цэргийн хүрээний цэргийн цагдаагийн тасгийн дарга
- Б.Даваадорж - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
- Д.Мөнхбат - Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн эмч
- Т.Баярсайхан - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- М.Бадарч - Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч
- А.Нямдэлгэр - Цагдаагийн газрын хэв журмын тасгийн албаны дарга
- Нарийн бичгийн дарга: Т.Амарсайхан - Бөхийн холбооны тэргүүлэгч

-oOo-